

ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2015 ОНЫ ЭХНИЙ 9 САРЫН БАЙДЛААР


ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ



Тус Цагдаагийн газар нь 2015 оны 09 дүгээр сарын байдлаар иргэд Аж ахуй нэгтж байгууллагаас **4559** гомдол, мэдээлэл хүлээн авсны 1013 буюу 22.2 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1896 буюу 41.6 хувь нь захиргааны зөрчлийн, 314 буюу 6,9 хувийг нь газар дээр очиж зохицуулсан, 156 буюу 3,4 хувь худал дуудлага байсан бөгөөд 836 буюу 18,3 хувь нь зөвөлгөө өгсөн, 264 буюу 5,8 хувийг нь саатуулах байран шилжүүлсэн байна.

Гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийн **379** буюу **37,4** хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэж, **634** буюу **62,6** хувийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтай прокурорт хүргүүлж шийдвэрлэсэн.


ШАЛГАЖ ШИЙДВЭРЛЭСЭН ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖТЭЙ
ГОМДОЛ МЭДЭЭЛЛИЙН 715 БУЮУ 70,6 ХУВИЙГ 5
ХОНОГТ, 298 БУЮУ 29,4 ХУВИЙГ 6-19 ХОНОГТ
ШИЙДВЭРЛЭСЭН БАЙНА.




ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН ШИНЖТЭЙ ГОМДОЛ
МЭДЭЭЛЛИЙН 607 БУЮУ 32 ХУВИЙГ ТОРГУУЛИЙН
ХУУДСААР, 811 БУЮУ 42,8 ХУВИЙГ ШИЙТГЭВЭРЭЭР
ТОРГОЖ, 191 БУЮУ 10,1 ХУВИЙГ БАРИВЧИЛЖ 284
БУЮУ 15 ХУВИЙГ ТЖЖВРИЙН ХЭРЭГСЭЛ ЖОЛООДОХ
ЭРХ ХАСЧ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙНА.



ШАЛГАЖ ШИЙДВЭРЛЭСЭН ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН ШИНЖТЭЙ ГОМДОЛ МЭДЭЭЛЛИЙН 1885 БУЮУ 99,4 ХУВИЙГ 14 ХОНОГТ, 11 БУЮУ 0,6 ХУВИЙГ 15-28 ХОНОГТ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙНА.



ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТ





□ Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцогдвол зохих этгээд нь тогтоогдоогүй 76 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 48 хэргийг нөхөн илрүүлж, гэмт хэргийн илрүүлэлт **63,2** хувьтай байгаа нь улсын дундаас буюу хэргийн илрүүлэлт хүрэх түвшингээс 3,2 хувиар илүү үзүүлэлттэй байна.




Гэмт хэргийн төрөл

■ Амиа хорлох гэмт хэрэг 2 бүртгэгдсэн нь 6 хэргээр буюу 75,0 хувь, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг 1 бүртгэгдсэн нь 1 хэргээр буюу 50 хувь, ТХХАБАЖЭГХ 36 бүртгэгдсэн нь 1 хэргээр буюу 2,7 хувиар, Байгал хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг 3 бүртгэгдсэн нь 1 хэргээр буюу 25 хувиартус тус буурсан, **Хулгайлах гэмт хэрэг 95 бүртгэгдсэн 36 хэргээр буюу 27.3 хувь (малын хулгай 39 буюу 48 хэргээр буюу 18,1 хувь, бусдын эд хөрөнгө хулгайлах 40 буюу 37 хэргээр буюу 48.0 хувь),** Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг 160 бүртгэгдсэн нь 60 хэргээр буюу 60 хувиар, Залилан мэхлэх гэмт хэрэг 14 бүртгэгдсэн нь 6 хэргээр буюу 75 хувиар, Завших гэмт хэрэг 7 бүртгэгдсэн нь 5 хэргээр буюу 2,5 дахин, Танхайрах гэмт хэрэг 13 бүртгэгдсэн 12 хэргээр буюу 12 дахин, Албан тушаалын эсрэг гэмт хэрэг 3 бүртгэгдсэн нь 2 хэргээр буюу 2 дахин өссөн байна.



ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН ЗАРИМ ОНЦЛОГ




□ Согтуугаар үйлдсэн хэрэг 100 бүртгэгдсэн нь 29 хэргээр буюу 41 хувиар, эмэгтэй хүн оролцсон хэрэг 39 бүртгэгдсэн нь 10 хэргээр буюу 34,5 хувиар, хүүхэд оролцсон гэмт хэрэг 13 бүртгэгдсэн нь 62,5 хувь буюу 5 хэргээр, бүлэглэн үйлдсэн хэрэг 27 бүртгэгдсэн нь 68,8 хувиар буюу 11 хэргээр өссөн, 10, галт зэвсэгээр үйлдсэн хэрэг 2 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

□ Бүртгэгдсэн гэмт хэргийн 56 нь Даваа, 80 нь Мягмар, 48 нь Лхагва, 45 нь Пүрэв, 49 нь Баасан, 46 нь Бямба, 61 нь ням гарагт гарсан байна.


□ Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн 25,7 хувь нь согтуугаар, 24,7 хувь нь бүлэглэн үйлдсэн ба 7,9 хувь нь урьд шүүхээр ял шийтгэгдсэн хүмүүс байна.

Хэрэг гарсан цаг хугацаа, гараг




Даваа Мягмар Лхагва Пүрэв Баасан Бямба ням

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ




Гэмт хэргийн улмаас 14 хүн амь насаа алдаж, 190 хүн хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэж, байгууллага, иргэдэд 667,1 сая төгрөгний хохирол учирч, түүний 488,4 сая төгрөгийг нөхөн төлүүлжээ.

Гэмт хэрэг үйлдэгчийн насаар



ЗАХИРГААНЫ ЗӨРЧИЛ



2015 оны эхний 9 сарын байдлаар согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн үедээ зөрчил гаргаж 1948 хүн саатуулагдсан нь өмнөх оны мөн үеэс 400 хүнээр буюу 17 хувиар буурсан байна. Зөрчил гаргасан 5579 иргэн, 9 аж ахуй нэгж байгууллагад нийт 49,648,300 төгрөгийн торгууль ногдуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон удаа дараа эрүүлжүүлэгдсэн, жижгээр танхайрсан зөрчилд 224 хүнийг 7-30 хоногийн хугацаагаар баривчилж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 334 жолоочийн эрхийг хасах арга хэмжээ авчээ.